

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Богд сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/161/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2024.02.23

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	4
Аудитын гол асуудал.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



БОГД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БУРМАА ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/54
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богд сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн.

Засаг даргын нөөц хөрөнгөөс зориулалт бусаар хөрөнгө зарцуулсан 534.0 мянга, Эмэгтэйчүүдийн зөвлөлд 2,800.0 мянган төгрөг, "Гэр бүлийн андгай өргөх ёслол, Иргэний андгай өргөх ёслол" д 800.0 мянган төгрөг зарцуулсан.

Цалин, НДШ, ХХОАТ-ын тооцоололтой холбоотой зөрчилд 1,292.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хувь хүний орлогын албан тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн хуулийн заалтуудыг зөрчсөн байна.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

5020211

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын газар эзэмшихтэй холбоотой нь зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	56,047,128.00	77,989,358.00
33	АВЛАГА	0	12,000,000.00
33500	Бусад авлага	0	12,000,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	12,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	56,047,128.00	65,989,358.00
35400	Хангамжийн материал	53,807,128.00	61,629,358.00
35410	Бичиг хэргийн материал	6,360,475.00	7,735,975.00
35470	Бусад хангамжийн материал	47,446,653.00	53,893,383.00
35600	Мал амьтад	2,240,000.00	4,360,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	893,925,154.14	1,132,657,859.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	893,925,154.14	1,132,657,859.25
39200	Биет хөрөнгө	880,337,154.14	1,119,069,859.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	546,303,068.84	807,546,824.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	-176,190,459.10	-202,701,780.07
39203	Авто-тээврийн хэрэгсэл	230,864,800.00	182,880,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-150,423,966.29	-91,520,833.60
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	156,114,165.50	140,686,004.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-138,863,650.76	-102,396,847.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	198,754,411.20	211,293,411.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-82,610,517.72	-102,060,230.36
39209	Зам, гүүрийн байгууламж	438,474,252.00	449,472,031.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-211,355,427.56	-226,849,646.30
39214	Бусад үндсэн хөрөнгө	227,933,200.00	219,725,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-158,962,721.97	-167,304,774.50
39217	Ном	300,000.00	300,000.00
39300	Биет бус хөрөнгө	13,588,000.00	13,588,000.00
39301	Программ хангамж	559,000.00	559,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-559,000.00	-559,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,588,000.00	13,588,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	949,972,282.14	1,210,647,217.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	133,508.00	433,508.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	133,508.00	433,508.00
41300	Өглөг	133,508.00	433,508.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	133,508.00	133,508.00
41360	Бусад өглөг	0	300,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	300,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	949,838,774.14	1,210,213,709.25

Богд сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	949,838,774.14	1,210,213,709.25
51100	Засгийн газрын оруулсан капитал	474,836,479.36	474,836,479.36
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	474,836,479.36	474,836,479.36
51200	Хуримтлагдсан үр дүн	317,574,900.23	577,949,835.34
51210	Өмнөх үеийн үр дүн	392,252,808.76	329,574,900.23
51220	Тайлант үеийн үр дүн	-74,677,908.53	248,374,935.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	157,427,394.55	157,427,394.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	949,972,282.14	1,210,647,217.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	542,739,948.00	1,038,840,492.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,023,890.00	336,559,275.00
120	Нийтлэг татварын бус орлого	66,023,890.00	336,559,275.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,252,790.00	128,940.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	128,940.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,252,790.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	56,771,100.00	2,120,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	334,310,335.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	476,716,058.00	702,281,217.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,264,058.00	55,265,817.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,264,058.00	55,265,817.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	461,452,000.00	647,015,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	461,452,000.00	647,015,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	617,417,856.53	777,965,556.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	617,417,856.53	777,965,556.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	573,088,861.25	770,962,158.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,571,347.19	393,269,681.59
210101	Үндсэн цалин	251,571,347.19	291,963,168.90
210102	Нэмэгдэл	0	84,313,303.09
210104	Урамшуулал	0	16,993,209.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,402,229.46	50,308,251.09
210201	Тэтгэврийн даатгал	21,848,293.06	34,850,514.49
210202	Тэтгэмжийн даатгал	2,505,196.35	3,932,696.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,004,157.25	2,952,994.10
210204	Ажилгүйдлийн даатгал	456,271.57	928,038.81
210205	Эрүүл мэндийн даатгал	4,588,311.23	7,644,006.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,798,040.00	23,900,481.36
210301	Гэрэл, цахилгаан	4,542,250.00	5,772,680.00
210302	Түлш, халаалт	15,255,790.00	17,127,801.36
210303	Цэвэр, бохир ус	0	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,566,885.07	78,295,047.00

Богд сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	5,176,550.00	9,019,500.00
210402	Тээвэр, шатахуун	31,857,830.00	40,036,585.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	922,274.99	3,256,000.00
210404	Ном, хэвлэл	78,000.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,755,230.08	12,780,362.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	75,000.00	12,862,600.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	1,702,000.00	40,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,791,000.00	8,937,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	139,000.00
210604	Урсгал засвар	26,791,000.00	8,798,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,606,700.00	8,908,000.00
210702	Дотоод албан томилолт	2,606,700.00	8,908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,879,057.00	62,877,848.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,275,457.00	57,915,750.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	762,724.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	1,123,653.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,603,600.00	1,415,200.00
210807	Газрын төлбөр	0	1,528,521.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,473,602.53	144,465,849.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,301,639.00	38,323,920.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	1,767,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,171,963.53	104,374,929.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,328,995.28	7,003,397.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,175,668.00	2,240,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,575,668.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,600,000.00	2,240,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	27,153,327.28	4,763,397.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,066,401.28	4,745,500.96
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,086,926.00	17,897.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-74,677,908.53	260,874,935.35
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	12,500,000.24
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0	12,500,000.24
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-74,677,908.53	248,374,935.11

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	485,968,848.00	702,410,157.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,252,790.00	128,940.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,252,790.00	128,940.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,252,790.00	128,940.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,252,790.00	128,940.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	476,716,058.00	702,281,217.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,264,058.00	55,265,817.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,264,058.00	55,265,817.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	461,452,000.00	647,015,400.00

Богд сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	461,452,000.00	647,015,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	480,968,848.00	681,112,857.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	480,968,848.00	681,112,857.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	436,639,852.72	673,759,459.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,571,347.19	394,982,738.17
210101	Үндсэн цалин	251,571,347.19	271,250,831.01
210102	Нэмэгдэл	-	123,731,907.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,402,229.46	48,595,194.51
210201	Тэтгэврийн даатгал	21,848,293.06	33,109,212.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,505,196.35	3,924,657.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,004,157.25	3,143,102.02
210204	Ажилгүйдлийн даатгал	456,271.57	739,764.01
210205	Эрүүл мэндийн даатгал	4,588,311.23	7,678,458.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,314,840.00	23,586,761.36
210301	Гэрэл, цахилгаан	4,785,625.00	5,206,929.36
210302	Түлш, халаалт	15,529,215.00	17,379,832.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,541,084.07	66,306,147.00
210401	Бичиг хэрэг	5,304,550.00	8,706,680.00
210402	Тээвэр, шатахуун	27,534,160.00	36,890,605.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	982,374.99	1,810,600.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,999,999.08	13,693,662.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	4,904,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	13,139,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	115,500.00
210604	Урсгал засвар	13,500,000.00	13,023,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,606,700.00	8,558,000.00
210702	Дотоод албан томилолт	2,606,700.00	8,558,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,102,882.00	73,692,698.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,538,882.00	67,230,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	762,724.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	1,123,653.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	2,915,600.00
210807	Газрын төлбөр	-	1,528,521.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,100,770.00	44,898,920.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,100,770.00	43,205,920.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,693,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,328,995.28	7,353,397.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,175,668.00	2,590,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,575,668.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,600,000.00	2,590,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	27,153,327.28	4,763,397.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,066,401.28	4,745,500.96
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,086,926.00	17,897.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,000,000.00	21,297,300.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,000,000.00	21,297,300.00



Богд сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00	21,297,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	21,297,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,000,000.00	21,297,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,000,000.00)	(21,297,300.00)
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	27,153,327.00	-
8	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	392,252,808.76	1,024,516,682.67
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	392,252,808.76	1,024,516,682.67
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-74,677,908.53	-74,677,908.53
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	317,574,900.23	949,838,774.14
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	317,574,900.23	949,838,774.14
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	12,000,000.00	12,000,000.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	329,574,900.23	961,838,774.14
19	Тайлант үеийн үр дүн	0	0	248,374,935.11	248,374,935.11
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	577,949,835.34	1,210,213,709.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны		Гүйцэтгэл зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	648,015,400.00	642,398,839.04	1,290,414,239.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	648,015,400.00	642,398,839.04	1,290,414,239.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	645,415,400.00	639,808,839.04	1,285,224,239.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	399,436,200.00	394,982,738.17	794,418,938.17
210101	Үндсэн цалин	275,646,100.00	271,250,831.01	546,896,931.01



Богд сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	123,790,100.00	123,731,907.16	247,522,007.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,061,900.00	48,595,194.51	97,657,094.51
210201	Тэтгэврийн даатгал	33,324,500.00	33,109,212.90	66,433,712.90
210202	Тэтгэмжийн даатгал	3,934,300.00	3,924,657.31	7,858,957.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,147,500.00	3,143,102.02	6,290,602.02
210204	Ажилгүйдлийн даатгал	786,800.00	739,764.01	1,526,564.01
210205	Эрүүл мэндийн даатгал	7,868,800.00	7,678,458.27	15,547,258.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,699,900.00	23,586,761.36	47,286,661.36
210301	Гэрэл, цахилгаан	5,317,000.00	5,206,929.36	10,523,929.36
210302	Түлш, халаалт	17,382,900.00	17,379,832.00	34,762,732.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,342,000.00	66,306,147.00	132,648,147.00
210401	Бичиг хэрэг	8,707,100.00	8,706,680.00	17,413,780.00
210402	Тээвэр, шатахуун	36,900,000.00	36,890,605.00	73,790,605.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,810,600.00	1,810,600.00	3,621,200.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	300,000.00	600,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,700,000.00	13,693,662.00	27,393,662.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,924,300.00	4,904,600.00	9,828,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,148,600.00	23,117,500.00	46,266,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,100,000.00	10,094,000.00	20,194,000.00
210604	Урсгал засвар	13,048,600.00	13,023,500.00	26,072,100.00
2107	Томилолт, зочны зардал	8,691,500.00	8,558,000.00	17,249,500.00
210702	Дотоод албан томилолт	8,691,500.00	8,558,000.00	17,249,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,035,300.00	26,873,578.00	53,908,878.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,426,600.00	20,411,080.00	40,837,680.00
210803	Даатгалын үйлчилгээ	787,800.00	762,724.00	1,550,524.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,226,900.00	1,123,653.00	2,350,553.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	148,000.00	132,000.00	280,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,916,000.00	2,915,600.00	5,831,600.00
210807	Газрын төлбөр	1,530,000.00	1,528,521.00	3,058,521.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,000,000.00	47,788,920.00	95,788,920.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,300,000.00	46,095,920.00	92,395,920.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,700,000.00	1,693,000.00	3,393,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,600,000.00	2,590,000.00	5,190,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,600,000.00	2,590,000.00	5,190,000.00

Богд сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,600,000.00	2,590,000.00	5,190,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	648,015,400.00	642,398,839.04	1,290,414,239.04
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	539,615,400.00	642,269,899.04	1,181,885,299.04
320001	Орон нутгийн төсвөөс	539,615,400.00	642,269,899.04	1,181,885,299.04
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	108,400,000.00	128,940.00	108,528,940.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	128,940.00	1,128,940.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	107,400,000.00	0	107,400,000.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	43	43	86.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	2.00
610001	Төсвийн байгууллага	1	1	2.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	21	21	42.00
620001	Удирдах ажилтан	8	8	16.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	22.00
620003	Үйлчлэх ажилтан	2	2	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	21	42.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7	7	14.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	12.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	16.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Богд сумын ЗДТГ нь "Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сумын орон нутгийн нийгэм эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсыг чандлан сахиулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албан хэрэгжүүлдэг бөгөөд 2022 оны шатахуун зарцуулалтын үйл ажиллагаанд дотоод аудит, зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Богд сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс 2022 онд хэвлүүлсэн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Богд сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 260,374.9 мянган төгрөг буюу 27 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	-	12,000.0	12,000.0
БАРАА МАТЕРИАЛ	56,047.1	65,989.4	9,942.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,812,890.9	2,026,051.0	213,160.1
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(918,965.7)	(893,393.1)	25,572.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	949,972.3	1,210,647.2	260,674.9
Засгийн газрын хувь оролцоо	133.5	433.5	300.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	949,838.8	1,210,213.7	260,374.9

Авлага данс: Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий моторыг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн чиглэлийг үндэслэн үндсэн хөрөнгөөс хасаж авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 65,989.4 мянган төгрөг болж 9,942.2 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар / захирамжаар 2,120.0 мянган төгрөгийн малыг хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 92,092.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 82,110.7 мянган төгрөгийн материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,026,051.0 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэл 213,160.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд байгууллагын төсвийн хөрөнгөөр 21,297.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, сумын ИТХ-ын 2023.12.18-ны өдрийн 13/04 дүгээр тогтоолоор 314,000.0 мянган хөрөнгийг үнэ төлбөргүй бүртгэсэн, аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.10.11-ны өдрийн 16/49 дүгээр тогтоолоор 60,457.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан, 2023.05.12-ны өдрийн 14/30 дугаар тогтоолыг /69,990.0 төгрөгийн анхны өртөгтэй 2 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаанд оруулах/ үндэслэн данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,210,213.7 мянган төгрөг болж 260,374.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 628,137.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 628,137.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 38,451.2 мянган төгрөгөөр бууруулж 589,686.3 мянган төгрөгөөр баталсан байна. Төсөвт сумын ИТХ-ын хуралдааны 2023.07.27-ны өдрийн тогтоолоор тодотгол хийж 648,015.4 мянган төгрөгөөр баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 647,015.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 128.9 мянган төгрөгийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 642,398.8 мянган төгрөгийг зарцуулан, 4,745.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 642,398.8 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэлтэй холбоотой зардал 394,982.7 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 48,595.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 23586.7 мянга, тээвэр шатахуун 36,890.6 мянга, Засаг даргын нөөц хөрөнгө 46,095.9 мянган төгрөг зарцуулсан нь голлох нөлөө үзүүлж байна. Төсвийн хэмнэлт 4,745.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 55,265.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 55,247.9 мянган төгрөгийг зарцуулж 17.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шатахуун нийлүүлэх гэрээг Жаргалант богд ХХК-тай, дулаанаар хангах гэрээг Энх Мөнх ХХК-тай шууд гэрээ байгуулан ажилласан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Богд сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хэрэгжүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 648,015.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,480.1 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,536.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны гэрэл цахилгааны зардлыг 110.1 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Богд сумын Засаг даргын 2023.03.28-ны өдрийн А/37 дугаар “Шашин урлагийн цэнгүүн” -д 534.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4. “хуулиар зөвшөөрөөгүй бусад” арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд төсвийн захирагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 647,061.7 мянган төгрөгийн 29 мэдээлэл, 6.4.8 “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” -д заасан 52,714.0 мянган төгрөгийн 144 мэдээллийг завсрын аудитаар нөхөн оруулж зөрчлийг арилгасан. Аудитаа зөрчил арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар цалин, НДШ төлөлт тайлан мэдээтэй холбоотой 2023 оны 4 сард 124.2 мянган төгрөгийн цалин илүү олгосон, НДШ-ийн мэдээнд 550.0 мянган төгрөгөөр илүү мэдээлснээс 104.5 мянган төгрөгийн зөрүү үүссэн зөрчил илэрч аудитын хугацаанд бүрэн залруулсан болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, аудитаар нийт 40,493.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 2/114 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	4,022.5	2	4,022.5	100%
Албан шаардлага	3	35,671.0	3	35,671.0	100%
Зөвлөмж	2	800.0	2	800.0	100%
Нийт дүн	7	40,493.5	7	40,493.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар анхаарал татсан асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 228.7 мянган төгрөгийн 2 алдаа¹, зөрчлийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Завсрын аудитаар цалин, НДШ төлөлт тайлан мэдээтэй холбоотой 2023 оны 4 сард 124.2 мянган төгрөгийн цалин илүү олгосон, НДШ-ийн мэдээнд 550.0 мянган төгрөгөөр илүү 104.5 мянган төгрөгийн зөрүү үүссэн нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Аж ахуйн материалын эхний үлдэгдэл 47,446.7 мянган төгрөг э тайланд бусад хангамжийн материалын эхний үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, мөн ангилал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 5,426.0 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс 1,826.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, зөрчил арилгах 2 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,426.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 4,536.1 мянган төгрөгөөс их тул Хязгаарлалтай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цалингаас суутгасан ХХОАТ-ыг давтан тооцоолоход Д.Ганболдын цалингаас 2023 оны 1-8 сарын цалин тооцож олгохдоо ХХОАТ тооцож суутган тооцоогүй байна.

Хувь хүний орлогын албан тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1.энэ хуулийн 15.1, 16.1.1, 17.1.2, 17.1.3-т тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар тооцон тухай бүр албан татвар ногдуулан, дараа сарын 15-ны өдрийн дотор; төсөвт төлнө гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иргэн Д.Ганболдоор буцаан төлүүлэх, төлбөрийн актыг тогтоов.

5.1.2 2023 оны 7 сард Анхбаярт ур чадварын нэмэгдэл шийдвэргүйгээр олгосон. бгэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн актыг тогтоов.

5.1.3 Засаг даргын нөөц хөрөнгөөс Богд сумын Засаг даргын 2023.03.28-ны өдрийн А/37 дугаар захирамжаар шашин урлагийн цэнгүүнд 534,0 мянган төгрөгийг зарцуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагчаар буцаан төлүүлэх, төлбөрийн актыг тогтоов.

5.2 Албан шаардлага

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.1 Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 удаагийн захирамжаар Эмэгтэйчүүдийн зөвлөлд 2,800.0 мянган төгрөг, "Гэр бүлийн андгай өргөх ёслол, Иргэний андгай өргөх ёслол" д 800.0 мянган төгрөг зарцуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1.4."хуулиар зөвшөөрөөгүй бусад арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Богд сумын ЗДТГ-ын газар эзэмших гэрчилгээг нягтлан бодох бүртгэл, аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 26994 мкв талбай бүхий 14 газар байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын газар эзэмших гэрчилгээний баримт бичгийн зөрчлийг арилгаж газрыг дахин үнэлж нягтлан бодох бүртгэлд бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн	2	228.7			2	228.7				
Санхүүгийн тайланд бүртгээгүй										
Дүн	2	228.7			2	228.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		/мянган төгрөгөөр/			
					Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2023 оны 1-8 сарын цалин тооцож олгохдоо Д.Ганболдын цалингаас ХХОАТ тооцож суутгаагүй	1	988.7	1	988.7				
2023 оны 7 сард Анхбаярт ур чадварын нэмэгдэл шийдвэргүйгээр олгосон	1	303.3	1	303.3				
Засаг даргын нөөц хөрөнгөөс Богд сумын Засаг даргын 2023.03.28-ны өдрийн А/37 дугаар захирамжаар шашин урлагийн цэнгүүнд 534,0 мянган төгрөгийг зарцуулсан.	1	534.0	1	534.0				
Богд сумын ЗДТГ-ын газар эзэмших гэрчилгээг нягтлан бодох бүртгэл, аймгийн ГХБХБГ-аас					1	0		

Богд сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 26994 кв талбай бүхий 14 газар байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлгүй байна.								
Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 удаагийн захирамжаар Эмэгтэйчүүдийн зөвлөлд 2,800.0 мянган төгрөг, "Гэр бүлийн андгай өргөх ёслол, Иргэний андгай өргөх ёслол" д 800.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.					1	3600.0		
Нийт дүн	5	5,426.0	3	1,826.0	2	3600.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 647,061.7 мянган төгрөгийн 29 мэдээлэл, 6.4.8 "Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл" -д заасан 52,714.0 мянган төгрөгийн 144 мэдээллийг завсрын аудитаар нөхөн мэдээлсэн	1	0					1	0
Дүн	1	0					1	0

-----oO-----